

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомж

2.1.Хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Хувь хүний нууцын тухай хууль³, Нийтийн мэдээллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар хүн, хуулийн этгээд нь хүний хувийн мэдээлэл /цаашид “мэдээлэл” гэх/ цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

3.2.Энэ хууль нь дараах харилцаанд үйлчлэхгүй:

3.2.1.хувь хүн өөрт болон өөрийн гэр бүлийн гишүүнд хамааралтай мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах;

3.2.2.хувь хүн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалах зорилгоор дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах;

3.2.3.хувь хүн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хадгалах зорилгоор өөрийн биометрик мэдээллийг ашиглах;

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Хувь хүний нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.3.Гүйцэтгэх ажлын явцад хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбоотой харилцааг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар⁴ зохицуулна.

3.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газар, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахтай холбоотой харилцааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хувь хүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;

4.1.2.“хүний эмзэг мэдээлэл” гэж Хувь хүний нууцын тухай хуулийн 4.1-д заасан болон хувь хүний үндэс, угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, итгэл үнэмшил, санхүү, генетик, биометрик, цахим гарын үсэг, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн чиг хандлага, бэлгийн амьдралын талаарх мэдээллийг;

4.1.3.“хүний хувийн мэдээлэл цуглуулах” гэж хүний хувийн мэдээлэл олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;

4.1.4.“хүний хувийн мэдээлэл боловсруулах” гэж хүн, эсхүл техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хүний хувийн мэдээллийг ангилах, хадгалах, өөрчлөх, устгах, дүн шинжилгээ хийх, сэргээх үйл ажиллагаа болон эдгээрийн нийлбэрийг;

4.1.5.“хүний хувийн мэдээлэл ашиглах” гэж хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаанд хэрэглэх болон дамжуулах, танилцахыг;

4.1.6.“мэдээллийн эзэн” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнийг;

4.1.7.“мэдээлэл хариуцагч” гэж хуульд заасан, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зорилго, хүрээг тодорхойлох, удирдлага, зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үүрэг бүхий хүн, хуулийн этгээдийг;

4.1.8.“генетикийн мэдээлэл” гэж биологийн сорьцын шинжилгээгээр тогтоосон хувь хүний бие махбодь, эрүүл мэнд, өвлөн авсан удамшлын шинж чанарыг илэрхийлсэн дахин давтагдашгүй мэдээллийг;

⁴ Гүйцэтгэх ажлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

4.1.9.“биометрик мэдээлэл” гэж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хувь хүнийг тодорхойлох боломжтой гарын хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүр царай, дуу хоолой зэрэг хувь хүний бие махбодитой холбоотой биеийн давхцахгүй өгөгдлийг;

4.1.10.“эрүүл мэндийн мэдээлэл” гэж хувь хүний бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг;

4.1.11.“цахим тодорхойлогч” гэж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамж, интернэт протоколын хаяг, цахим хэлбэрээр хувь хүнийг тодорхойлох боломжтой мэдээлэл, радио давтамж болон эдгээрийн нийлбэрийг;

4.1.12.“хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгох” гэж хүний хувийн мэдээллийг тухайн хувь хүнд хамааруулах боломжгүй байдлаар боловсруулахыг;

4.1.13.“даруй” гэж хамгийн боломжит богино хугацааг.

4.2.Энэ хуулийн 4.1.6-д заасан хүн Иргэний хуулийн 16-19 дүгээр зүйлд заасан иргэн бол түүний хууль ёсны төлөөлөгч нь мэдээллийн эзэн байна.

5 дугаар зүйл.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахад баримтлах зарчим

5.1.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахад дараах зарчим баримтална:

5.1.1.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх;

5.1.2.хувийн мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтгүй байх;

5.1.3.мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах;

5.1.4.мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

5.1.5.мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХ

6 дугаар зүйл.Мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл авах

6.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр мэдээлэл цуглуулна.

6.2.Мэдээллийн эзэнд дараах нөхцөлийг танилцуулж, зөвшөөрөл авна:

6.2.1.мэдээлэл цуглуулах үндэслэл, зорилго;

6.2.2.мэдээлэл хариуцагчийн нэр, хуулийн этгээд бол оноосон нэр, холбоо барих мэдээлэл;

- 6.2.3.боловсруулах мэдээллийн жагсаалт;
- 6.2.4.мэдээлэл боловсруулах, хадгалах хугацаа;
- 6.2.5.мэдээллийг ил болгох эсэх;
- 6.2.6.мэдээллийг бусдад дамжуулах эсэх;
- 6.2.7.зөвшөөрлөө цуцлах нөхцөл.

6.3.Зөвшөөрлийг мэдээлэл хариуцагчид бичгээр өгнө. Бичгээр өгөх зөвшөөрөл нь цаасан болон цахим хэлбэртэй байна.

6.4.Иргэний хуулийн 16-19 дүгээр зүйлд заасан иргэний мэдээллийг цуглуулахад түүний хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авна.

6.5.Мэдээлэл цуглуулах зөвшөөрөлд мэдээллийн эзэн хариу өгөөгүй бөгөөд ийнхүү хариу өгөхөөр тогтоосон хугацаа, эсхүл ердийн боломжит хугацаа өнгөрсөн нь мэдээлэл цуглуулахыг зөвшөөрсөнд тооцохгүй.

6.6.Мэдээллийн эзэн өгсөн зөвшөөрлөө хэдийд ч цуцалж болох бөгөөд цуцлах тухай хүсэлтийг хүлээн авснаас өмнөх хугацаанд хийгдсэн мэдээлэл боловсруулалт нь хууль ёсны хэвээр үлдэнэ.

6.7.Мэдээлэл хариуцагч нь мэдээлэл цуглуулахад мэдээллийн эзний зөвшөөрөлтэй болохыг нотлох үүрэгтэй.

6.8.Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзний мэдээллийг дамжуулахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах бөгөөд энэ хуулийн 6.3-т заасан хэлбэртэй байна. Энэ хуулийн 6.4, 6.5, 6.6, 6.7-д заасан зохицуулалт нь мэдээлэл дамжуулах зөвшөөрөл авахад нэгэн адил үйлчилнэ.

7 дугаар зүйл.Төрийн байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

7.1.Төрийн байгууллага дараах тохиоодолд мэдээлэл цуглуулж, боловсруулна:

- 7.1.1.хуульд заасан бол;
- 7.1.2.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 7.1.3.хувь хүнтэй гэрээ байгуулах, байгуулсан гэрээний хэрэгжилтийг

хангах;

7.1.4.мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тохиолдолд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх;

7.1.5.мэдээллийн эзний зөвшөөрлөөр.

7.2.Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээллийг ашиглана:

7.2.1.хуульд заасан бол;

7.2.2.Үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

7.2.3.мэдээллийн эзний амь нас, бие махбодь, эрх, эрх чөлөө, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

7.2.4.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

7.2.5.хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийх;

7.2.6.мэдээллийн эзний зөвшөөрлөөр.

7.3.Төрийн байгууллага хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

8 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

8.1.Хүн, хуулийн этгээд дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана:

8.1.1.хуульд заасан бол;

8.1.2.хувь хүнтэй гэрээ байгуулах, байгуулсан гэрээний дагуу эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх;

8.1.3.мэдээллийн эзэн өөрөө, эсхүл хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;

8.1.4.хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийх;

8.1.5.мэдээллийн эзний зөвшөөрлөөр.

9 дүгээр зүйл.Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

9.1.Хүний эмзэг мэдээлэл цуглуулахад мэдээллийн эзний зөвшөөрлийг цаасан, эсхүл тоон гарын үсэг хэрэглэн цахим хэлбэрээр авна.

9.2.Доор дурдсанаас бусад тохиолдолд хүний эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно:

9.2.1.хуульд заасан бол;

9.2.2.хуульд заасан тохиолдолд хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцагч эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх;

9.2.3.мэдээллийн эзний амь нас, бие махбодид хохирол учрах зайлшгүй нөхцөл байдал үүссэн;

9.2.4.хувь хүн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтан хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх;

9.2.5.хуулиар, эсхүл мэдээллийн эзэн мэдээллийг нийтэд ил болгосон;

9.2.6.хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийх;

9.2.7.иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагад хуульд заасны дагуу тайлбар, мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх;

9.2.8.мэдээллийн эзэн нь Иргэний хуулийн 16-19 дүгээр зүйлд заасан иргэн бол түүний хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

9.2.9.мэдээллийн эзний зөвшөөрлөөр.

9.3.Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд баримтлах журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар батална.

10 дугаар зүйл.Биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

10.1.Доор дурдсан төрийн байгууллага дараах зорилгоор хувь хүнийг таньж, баталгаажуулахад мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр биометрик мэдээллийг цуглуулж, ашиглана:

10.1.1.цахим хэлбэр бүхий сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх зорилгоор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хувь хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг;

10.1.2.улсын хилээр нэвтэрч байгаа хувь хүнийг таних, баталгаажуулах зорилгоор хил хамгаалах байгууллага хувь хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг;

10.1.3.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллага хувь хүний биеийн давхцахгүй өгөгдлийг;

10.1.4.эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шинжилгээ хийхэд хувь хүний биеийн давхцахгүй өгөгдлийг.

10.2.Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтныг таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор ажил олгогч ажилтны биометрик мэдээллийг цуглуулж, ашиглаж болно. Ажил олгогч биометрик мэдээллийг цуглуулж, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллана.

10.3.Мэдээлэл хариуцагчийн энэ хуулийн 24.1.2-т заасан журмын дагуу тогтоосон мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан нь мэдээлэл алдагдсанаас үүсэх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11 дугаар зүйл.Түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээ

хийх, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

11.1.Хуульд өөрөөр заагаагүй бол түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийх, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор мэдээллийн эзнээс зөвшөөрөл авч, мэдээлэл цуглуулна.

11.2.Мэдээлэл цуглуулсан зорилгоос үл хамааран түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийх, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор мэдээлэл боловсруулж, ашиглаж болно.

11.3.Хуульд өөрөөр заасан, эсхүл мэдээллийн эзэн бичгээр зөвшөөрөл өгсөнөөс бусад тохиолдолд хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож, мэдээлэл боловсруулж, ашиглана.

11.4.Хуульд өөрөөр заасан, эсхүл мэдээллийн эзэн бичгээр зөвшөөрөл өгсөнөөс бусад тохиолдолд хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээний үр дүн, статистикийн мэдээлэл хэвлэн нийтэлнэ.

11.5.Энэ хуулийн 11.1-д заасан зорилгоор мэдээлэл боловсруулж, ашиглахад мэдээллийн эзэнд энэ хуулийн 15.1.1-15.1.3 дахь заалт хамаарахгүй.

11.6.Түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийх, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор мэдээлэл боловсруулах, ашиглахад энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аюулгүй байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

12.1.Хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийн эзний зөвшөөрлөөр, эсхүл нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж болно.

13 дугаар зүйл.Мэдээллийн эзэн нас барсны дараа мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах

13.1.Мэдээллийн эзэн нас барсан, эсхүл нас барсанд тооцогдсон бол түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр түүнд хамаарах мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана.

13.2.Мэдээллийн эзэн нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй.

14 дүгээр зүйл.Мэдээллийг хилийн чанадад дамжуулах

14.1.Мэдээллийг мэдээллийн эзний бичгээр өгсөн зөвшөөрлөөр, эсхүл хуульд заасан үндэслэлээр хилийн чанадад дамжуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

15 дугаар зүйл.Мэдээллийн эзний эрх

15.1.Мэдээллийн эзэн дараах эрхтэй:

15.1.1.өөрт хамааралтай мэдээллийг цуглуулсан, боловсруулсан, ашигласан эсэхийг мэдэх;

15.1.2.энэ хуулийн 6.2-т заасан мэдээллийг мэдэх;

15.1.3.мэдээллийн эзэнд хамааралтай мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан, эсхүл дамжуулахаар бол тухайн гуравдагч этгээдийн талаар мэдэх;

15.1.4.мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр мэдээлэл цуглуулсан, боловсруулсан, ашигласан, мэдээллийг анх цуглуулсан зорилгод хүрсэн, эсхүл анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор мэдээллийг ашигласан гэж үзвэл өөрийн мэдээллийг устгуулах;

15.1.5.мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хориглосон, устгахаар заасан бол хэрэгжүүлэхийг шаардах;

15.1.6.өөрт хамаарах мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргуулан авах;

15.1.7.энэ хуулийн 15.1.6-д заасан мэдээллийн хуулбарыг өөрийн сонгосон мэдээлэл хариуцагчид дамжуулах;

15.1.8.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад цуцлах хүсэлт гаргах, энэ тухайгаа мэдээлэл хариуцагчид бичгээр мэдэгдэх;

15.1.9.мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд гарсан шийдвэрт гомдол, тайлбар гаргах, нэмэлт мэдээллийг оруулах, мэдээллийг дахин боловсруулахыг шаардах;

15.2.Мэдээллийн эзэн энэ хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, бусдын хууль бусаар учруулсан хохирол болон эдийн бус гэм хорыг арилгуулах эрхтэй.

16 дугаар зүйл.Мэдээллийн эзний үүрэг

16.1.Мэдээллийн эзэн дараах үүрэгтэй:

16.1.1.өөрт хамааралтай мэдээллийн үнэн зөв байдлыг хангах;

16.1.2.алдаатай мэдээллийг залруулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж өөрчлөлт оруулах, нэмэлт мэдээлэл өгч тусгуулах;

16.1.3.энэ хуулийн 15.1.7-д заасан эрхийг хэрэгжүүлэхдээ бусдын эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөхгүй байх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ БОЛОН БОЛОВСРУУЛАГЧ

17 дугаар зүйл.Мэдээлэл хариуцагч

17.1.Мэдээлэл хариуцагч хуульд заасан үндэслэл, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана.

17.2.Мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар дараах үүрэгтэй:

17.2.1.энэ хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх;

17.2.2.мэдээллийн эзнээс түүний мэдээлэл цуглуулах талаар зөвшөөрөл авах;

17.2.3.мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа энэ хуулийн 6.2-т заасан мэдээллээр хангах;

17.2.4.мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл өгөхөөс татгалзах болон мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой гомдол гаргах эрхийн талаар мэдээллийн эзэнд тайлбарлах;

17.2.5.мэдээллийн эзэн мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд үүсэж болох үр дагаврыг тайлбарлах;

17.2.6.мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд шийдвэр гаргах, түүнээс гарах үр дагаврын талаар мэдээллийн эзэнд тайлбарлах;

17.2.7.мэдээллийг мэдээллийн эзний албан ёсны баримт бичгийн эх хувь, эсхүл цахимаар илгээсэн баримт бичигт дурдсан мэдээлэлтэй тулгаж, бүртгэх;

17.2.8.мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээлэл боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх;

17.2.9.мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийг засах, өөрчлөх, устгах, энэ талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх;

17.2.10.мэдээллийн эзний хүсэлтийг хүлээн авсны дараа бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй тохиолдолд мэдээлэл боловсруулах, ашиглах үйл ажиллагааг цуцлах;

17.2.11.мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийн хуулбарыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй өгөх;

17.2.12.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар бүртгэл хөтлөх;

17.2.13.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;

17.2.14.мэдээллийн эзний гомдлыг хүлээн авч ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэх;

17.2.15.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар мэдээллийн эзэн, эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээх.

17.3.Энэ хуулийн 17.2.10-д заасан мэдээлэл боловсруулах, ашиглах үйл ажиллагааг цуцлах нөхцөл нь мэдээллийн эзэнд хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах үйл ажиллагааг цуцлахад хамаарахгүй.

17.4.Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзэнд хүндрэл үүсгэхгүйгээр, хялбар, ойлгомжтой байдлаар түүний хүсэлтийн дагуу зөвшөөрлийг цуцална.

18 дугаар зүйл.Мэдээлэл боловсруулагч

18.1.Мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан гэрээнд мэдээлэл цуглуулах, боловсруулах зорилго, гэрээний хугацаа, мэдээллийн ангилал, мэдээллийн эзний эрх хамгаалах нөхцөлийг тусгана.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол мэдээлэл боловсруулагч нь мэдээлэл хариуцагчийн өмнө хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхийг хориглох бөгөөд шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчид хүлээлгэх хариуцлагын талаар гэрээнд тодорхой тусгана.

18.4.Мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг шилжүүлэн авсан мэдээлэл боловсруулагч нь дараах үүрэгтэй байна:

18.4.1.мэдээллийн эзний өгсөн зөвшөөрлийн хүрээнд мэдээлэл хариуцагчийн хяналт дор мэдээлэл цуглуулах, боловсруулах;

18.4.2.мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврын дагуу мэдээллийн эзний мэдээллийг засах, өөрчлөх, устгах;

18.4.3.мэдээлэл цуглуулах, боловсруулахтай холбоотой шаардлагатай мэдээллийг мэдээлэл хариуцагчид өгөх;

18.4.4.мэдээлэл цуглуулах, боловсруулах зорилго биелсэн бол мэдээлэл болон мэдээлэл боловсруулснаас гарсан үр дүнг мэдээлэл хариуцагчид хуулбар авч үлдэлгүй гэрээнд заасан хугацаанд буцааж өгөх;

18.4.5.мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;

18.4.6.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

18.4.7.энэ хуулийн 17.2.1-д заасан журмын хүрээнд мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, зааврыг гүйцэтгэх.

18.5.Мэдээлэл боловсруулагч мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг зөрчсөн нь мэдээлэл хариуцагчийг мэдээллийн эзний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

18.6.Мэдээлэл хариуцагч нь мэдээлэл боловсруулагчид гэрээний үндсэн дээр мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг шилжүүлээгүй тохиолдолд энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасан үүргийг өөрөө гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

19 дүгээр зүйл. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

19.1.Мэдээлэл хариуцагч болон боловсруулагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

19.1.1.мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдөх;

19.1.2.мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг хуульд нийцүүлэн баталсан байх;

19.1.3.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгдэх мэдээллийн системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах бүхий л арга хэмжээг авсан байх;

19.1.4.мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох талаар тодорхой журам, зааварчилгаа баталж, мөрдөх;

19.1.5.мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор үнэлгээг хийх.

19.2.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, биометрик мэдээллийн тээгч, хадгалах технологид тавигдах шаардлагыг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

20 дугаар зүйл.Мэдээллийн эзэнд мэдэгдэл өгөх

20.1.Дараах тохиолдолд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд мэдэгдэл өгнө:

20.1.1.хүний эмзэг мэдээллийг ашигласан;

20.1.2.мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл боловсруулахаас бусад үндэслэл, зорилгоор мэдээлэл боловсруулахад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан.

20.2.Мэдээлэл хариуцагч мэдээллийн ангиллаас үл хамааран мэдэгдэл хүргүүлж болно.

21 дүгээр зүйл.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн талаар мэдэгдэх

21.1.Мэдээлэл боловсруулагч нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийг мэдсэн даруйд энэ тухай мэдээлэл хариуцагчид мэдэгдэнэ.

21.2.Зөрчил нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагч даруй мэдээллийн эзэнд мэдэгдэнэ.

21.3.Мэдээллийн эзэн энэ хуулийн 21.2-т заасан зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан гэж үзвэл хуульд заасны дагуу холбогдох байгууллагад гомдол гаргах эрхтэй.

21.4.Мэдээлэл хариуцагч нь зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлнө.

21.5.Энэ хуулийн 21.2-т заасан мэдэгдэл дараах мэдээллийг агуулсан байна:

21.5.1.зөрчилд хамаарах мэдээллийн эзэн, мэдээллийн бүртгэл;

21.5.2.мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээлэл;

21.5.3.зөрчлийн улмаас учирч болзошгүй сөрөг үр дагавар;

21.5.4.зөрчил, түүний улмаас учирч болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээ.

21.6.Мэдээлэл хариуцагч нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчилд өртсөн мэдээллийг шифрлэх болон хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож, мэдээлэл ашиглах эрхгүй этгээд хандахаас сэргийлж, зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь энэ хуулийн 21.2-т заасан мэдэгдэх нөхцөлийг хөндөхгүй.

21.7.Энэ хуулийн 21.4-т заасан бүртгэлийг жил бүр Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.

22 дугаар зүйл.Үнэлгээ хийх

22.1.Мэдээлэл хариуцагч хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж болох бөгөөд дараах тохиолдолд үнэлгээ хийнэ:

22.1.1.мэдээлэлд хүний оролцоогүй цахим хэлбэрээр хийх боловсруулалт нь мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах;

22.1.2.хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан үнэлгээг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлж, шийдвэр гаргуулсны үндсэн дээр цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана.

22.3.Энэ хуулийн 22.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний комиссын саналыг үндэслэн харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

23 дугаар зүйл.Хүний хувийн мэдээлэл хамгаалах талаар Хүний эрхийн Үндэсний комиссын чиг үүрэг

23.1.Хүнийн эрхийн Үндэсний комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахад хяналт тавих, олон нийтэд таниулах, сурталчлах талаар холбогдох байгууллагад зөвлөмж өгөх, холбогдох журамд санал өгөх;

23.1.2.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагааны явцад энэ хуулиар хамгаалагдсан хувь хүний эрх, эрх чөлөөнд халдсан, эсхүл халдаж болзошгүй нөхцөл бүрдүүлсэн гэж үзвэл энэ талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, шийдвэрлэх, эсхүл өөрийн санаачилгаар шалгаж, шийдвэрлэх, уг асуудлаар холбогдох байгууллагуудад зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

23.1.3.хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудад мэдээлэл өгөх, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх;

23.1.4.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа, гарсан зөрчил, мэдээллийн эзний эрхийн хэрэгжилтийн талаар тусгаж, жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд тайлан хүргүүлэх.

24 дүгээр зүйл.Цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах талаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

24.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон нийтэд таниулах, сурталчилах ажлыг явуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, чиглэл өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

24.1.2.хүний эмзэг болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмыг батлах;

24.1.3.мэдээлэл цуглуулах, дамжуулах зөвшөөрлийн жишиг загварыг батлах;

24.1.4.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн талаар мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авч бүртгэн, шаардлагатай арга хэмжээ авах.

25 дугаар зүйл.Цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэг

25.1.Харилцаа холбооны зохицуулах хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар Хүний эрхийн Үндэсний комисс, харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлэх;

25.1.2.мэдээлэл хариуцагч болон боловсруулагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлага хүргүүлэх;

25.1.3.мэдээллийн эзнээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;

25.1.4.мэдээллийн эзний эрхийг хамгаалах талаар мэдээлэл хариуцагч болон боловсруулагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

25.1.5.мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний талаар ирүүлсэн бүртгэлийг хүлээн авч хянан, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгөх;

25.1.6.мэдээлэл хариуцагчийн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ДУУНЫ, ДҮРСНИЙ, ДУУ-ДҮРСНИЙ БИЧЛЭГИЙН СИСТЕМ

26 дугаар зүйл.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем

26.1.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь технологийн тусламжтайгаар дууны, дүрсний, дуу-дүрсний мэдээлэл цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник хэрэгсэл, мэдээлэл дамжуулах сүлжээ, хадгалах төхөөрөмжөөс бүрдэнэ.

26.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж нь технологийн тусламжтайгаар дууны, дүрсний, дуу-дүрсний мэдээлэл цуглуулах, дамжуулах, хадгалах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник, хэрэгслээс бүрдэнэ.

26.3.Хуульд өөрөөр заагаагүй бол дараах зорилгоор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг байршуулж болно:

26.3.1.нийтийн зориулалттай орон сууцны орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайд оршин суугчдын аюулгүй байдлыг хамгаалах, дундын эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

26.3.2.ажлын байранд хувь хүний болон мэдээлийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

26.3.3.замын хөдөлгөөний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, түүнд дүн шинжилгээ хийх.

26.4.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 26.3-т заасны дагуу дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах болон бичлэгийг ашиглахдаа дараах үйл ажиллагааг хориглоно:

26.4.1.ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө зэрэг хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах;

26.4.2.нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах;

26.4.3.нийтийн зориулалттай орон сууцны дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дүрст болон дуут хэлбэрээр түгээх;

26.4.4.дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг харуулах, сонсгох, хуулбарлаж өгөх.

26.5.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг анхааруулгын хамт байршуулна.

26.6.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системд тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийг Хүний эрхийн үндэсний комиссын саналыг үндэслэн харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

26.7.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 26.3, 26.4-т заасан үйл ажиллагаа, бусад хуулийн хүрээнд ашиглаж буй дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно.

26.8.Хуульд заасан журмын дагуу дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системд байгаа мэдээлэлтэй танилцах, хандаж харах, хадгалагдсан бичлэгийг үзүүлэх, сонсгох, хуулбарлаж өгнө.

26.9.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байна.

26.10.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг гэмт хэрэг, зөрчлийн нотлох баримт болгох зорилгоор гаргуулан авах тохиолдолд холбогдох хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл.Хориглох зүйл

27.1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно.

27.2.Мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусад эх сурвалжаас боловсруулж, мэдээллийн эзнийг таньж, тодорхойлохыг хориглоно.

27.3.Энэ хуулийн 27.2-т заасан зохицуулалт нь хэвлэл мэдээллийн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд хамаарахгүй.

27.4.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргахыг хориглоно.

27.5.Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

28 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг